



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/698

Мандалговь

Согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчлэх цэгийн цагийн
хязгаарыг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 22 дугаар зүйлийн 22.2, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх цагийн хязгаарыг 1 дүгээр, сумын төвийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх цагийн хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ захирамжийг холбогдох хууль, журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг Хууль, эрх зүйн хэлтэс (Л.Баярсайхан)-д, тухайн аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Сар бүрийн 01, 15-ны өдрүүдэд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглосугай.

4. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд таниулах, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эерэг дадал зуршлыг бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, энэ төрлийн үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллахыг нийт төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

4823101525

Аймгийн Засаг даргын 2023 оны
 !! дугаар сарын 20-ны өдрийн 1/628
 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ТӨВИЙН НУТАГ ДЭВСГЭРТ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ,
 ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ЦЭГИЙН
 ЦАГИЙН ХЯЗГААР

д/д	Худалдаа үйлчилгээний төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар	
			Эхлэх	Дуусах
1	Согтууруулах ундаа “ХУДАЛДАХ” цагийн хязгаар	Бөөний болон агуулах худалдаа	09:00	22:00
		Жижиглэн худалдаа /Сүпермаркет/	09:00	00:00
		Жижиглэн худалдаа /Минимаркет/	09:00	23:00
2	Согтууруулах ундаагаар “ҮЙЛЧЛЭХ” цагийн хязгаар	Жуулчны бааз амралтын газар, зочид буудлын дэргэдэх ресторан, баар, кафе	11:00	22:00
			14:00	0:00
		Ресторан, кафе	11:00	22:00
			14:00	00:00
		Баар Караоке	11:00	22:00
			14:00	02:00

Аймгийн Засаг даргын 2023 оны
 дугаар сарын ... ны өдрийн
 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

СУМЫН ТӨВИЙН НУТАГ ДЭВСГЭРТ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР
 ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ЦЭГИЙН
 ЦАГИЙН ХЯЗГААР

Д/д	Худалдаа үйлчилгээний төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар	
			Эхлэх	Дуусах
1	Согтууруулах ундаа “ХУДАЛДАХ” цагийн хязгаар	Жижиглэн худалдаа /Сүпермаркет/	10:00	22:00
2	Согтууруулах ундаагаар “ҮЙЛЧЛЭХ” цагийн хязгаар	Жуулчны бааз амралтын газар, зочид буудлын дэргэдэх ресторан, баар, кафе	11:00	22:00
			14:00	00:00
		Ресторан, кафе	11:00	22:00
			14:00	22:00
		Баар Караоке	11:00	22:00
			14:00	00:00